



“ПЕТРО ЖАМП” ХХК-Д

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
E-mail: ub_info@inspection.gov.mn
http://www.ub.inspection.gov.mn

2017.02.13 № 02-01/550

танай _____-ны № _____-т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтран баталсан 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Агаарын чанарын сайжруулах бүсийг шинэчлэн тогтоох” тухай А/04-А/19 тоот тушаал, захирамжийн дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах шатахуун түгээх станц (ШТС), агуулах болон ШТС-ын ойр орчим, хамгаалалтын бүсэд “Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам”-ын хэрэгжилтийг хангуулахаар мэдэгдэх нь:

1. Агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйл шатаахгүй байх, MNS 5216:2016 стандартын шаардлага хангасан зуух ашиглах.

2. Үндэсний стандартын шаардлагыг хангасан цахилгаан болон бүх төрлийн халаагуур ашиглах.

3. Сэргээгдэх эрчим хүчний бие даасан болон бусад үүсгүүр /нар, салхи, усны эрчим болон гүний дулааныг ашиглан цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх байгууламж/-ийг ашиглах.

4. Био түлш /ургамал, амьтны гаралтай тосноос гарган авсан шингэн/ хэрэглэх.

Мэдэгдлийн дагуу арга хэмжээ аваагүй тохиолдолд “Агаарын тухай” хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, 31.1.5 дахь заалтын дагуу торгуулийн арга хэмжээ ногдуулах, тусгай зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох, газар эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгох саналыг холбогдох газарт хүргүүлэх зэрэг арга хэмжээ авахыг анхааруулан мэдэгдэж байна.

ДАРГА



Л. ЭРДЭНЭЧУЛУУН

1150509556